

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

САЙНШАНД СУМЫН 2 ДУГААР БАГ "ДЭНЖ-6" ГУДАМЖ НИЙТИЙН 618, 620 ДУГААР БАЙРНЫ ГАДНА ФАСАД, ДЭЭВРИЙН ЗАСВАР, ГАДНА ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН АЖИЛ

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **3 340 100 /Гурван сая гурван зуун дөчин мянга нэг зуу /** төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТХС-ын 2022.08.22-ны өдрийн А/233 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТХС-ын 2017 оны 212 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

З. Гэрэлтүүлэг суурилуултын ажлын явцад "Сайншанд сумын цахилгаан түгээх сүлжээ"-ээрхяналт тавиулж холбогдох актыг бүрдүүлэх.

И. Газар шорооны ажлын хийж гүйцэтгэхийн өмнө геодези хэмжилтийн эрхтэй байгууллагаар шугам трассын дагуу улаан шугам тавиулж илд далд ажлын актыг баталгаажуулсаны дараа ажлын эхлүүлэх шаардлагатай. Улаан шугам тавиулах үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байцуулна.

1. Гадна фасадны заслын ажил

Гадна фасадны засварын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 81-15-06, БНБД 81-02-03, БНБД 81-02-05, БНБД 81-02-08г мөрдлөг болгоно. Ажил гүйцэтгэх хугацаанд Барилга хот байгуулалтын сайдын 2017.11.30-ны 195 дугаар "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам"-ын мөрдлөг болгон ажиллана. Барилгын тамбургүй хэсэгт М150 маркын хашлага суурь цутган, М100 маркын хаяавч цутгах ажлыг/БНБД 52-01-10/ хийж гүйцэтгэнэ.

2. Дээврийн ажил

Дээврийн ажлын угсралтын ажлын гүйцэтгэх үед БНБД 31-07-05г мөрдлөг болгоно. Ажил гүйцэтгэх хугацаанд Барилга хот байгуулалтын сайдын 2017.11.30-ны

195 дугаар “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ын мөрдлөг болгон ажиллана. Харуулдсан банзан фронтон, цэвэр банзан карниз угрсахдаа Модон бүтээц БНБД 54-01-07 мөрдлөг болгон ажиллана.

3. Талбайн гэрэлтүүлгийн ажил

Гэрэлтүүлгийн шонд эрчим хүчний хэмнэлттэй 150Вт-ын “LED” технологийн гэрэлтүүлэгч толгой угсрана. LED гэрэлтүүлэгч нь -40°С-ээс +65°С хэмд ажиллах боломжтой байх /IP65/. Гэрэлтүүлгийн шонгууд нь зэвэрдэггүй ган төмөр, салхины хэт ачаалал бусад байгалийн нөлөөллийг тэсвэрлэх чадвартай болохыг баталсан баримт сертификаттай байна. Ажил гүйцэтгэхэд бетон зам, талбайн хучилт, явган замын хавтанг буулгаж, буцааж сэргээх. MNS 6805:2019 стандартыг хангаж ажиллах. Гэрэлтүүлгийн шон болон самбар, бүх тусгаарлагч сууриудыг норм дүрмийн дагуу газардуулна. /“БД30-102-11”/ Гэрэлтүүлгийг ажлын зурагт заасан чиглэлийн дагуу суурилуулна. Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэг 3ш-г угсрах

4. Тоглоомын талбайн хамгаалалтын хашааны ажил

Тоглоомын талбайн хамгаалалтын хашааны угсралтын ажилд “Ган бүтээц” БНБД 53-03-07, “Цутгамал бетон бүтээц” БНБД 3.03.01-88-г мөрдлөг болгоно. Ган хашааны өндөр 0,7 метртэй байх ба төмөр шонг суурилуулсаны дараа бетон суурь хийж бэхжүүлнэ. Суурийн бетоны марк БМ100 байна. Хашааны шон хоорондын зай 2 метр байх ба шонг тэгш хэмтэй жигд суулгаж өгнө. Шон хооронд цэвэр үзэмжтэй, гоёлын хийц хэв загвартай сайн чанарын төмөр сараалжин хашааг уртын дагууд угсарч хийнэ. Явган хүний гарцтай хэсэгт жижиг хаалга гаргаж өгнө.

Хашааг угсарж хийхдээ хүүхдийн аюулгүй байдлыг найдвартай хангахууц хашааны хөндлөн холбоосын их рамтай нь сайтар бэхлэж гагнах ба хашааны хөшүүн чанарыг сайтар хангах шаардлагатай.

Төмөр сараалжин хашаа, хашааны шонг цайрдсан ган төмрөөр хийнэ мөн хашааг угсарч дууссаны дараа хөрсжүүлэлт

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
9. Ажил гүйцэтгэж дууссаны дараа шугамын трассын дагуу геодези хэмжилтийн байгууллагаар гүйцэтгэлийн зураг гаргуулж ГХБХБГ-ын кадастрын мэдээллийн санд бүртгүүлнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

САЙНШАНД СУМЫН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

Б.Энхманлай

Б.ЭНХМАНЛАЙ